**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2024/198-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:

www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2024 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын дүгнэлт 4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 6

3. Санхүүгийн тайлангийн тодруулга 13

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 13

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 14

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 15

4. Аудитын тайлан 17

4.1 Ерөнхий зүйл 17

4.2 Материаллаг байдал 18

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 18

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 18

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 19

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 20

5. Аудитын илрүүлэлт 20

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2024. 02. 23 № СЭА-2024/198/НА-СТА-ТШ3

танай ______________-ны № ________________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 25,465.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

018020160

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **336,643,739.20** | **468,328,493.10** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **157,926,101.68** | **257,212,403.24** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **157,926,101.68** | **257,212,403.24** |
| **31210** | **Төгрөг** | **157,926,101.68** | **257,212,403.24** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 157,926,101.68 | 257,212,403.24 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **178,717,637.52** | **211,116,089.86** |
| **35100** | **Түүхий эд материал** | **116,400.00** | **116,400.00** |
| 35130 | Эм боох материал | 116,400.00 | 116,400.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **178,601,237.52** | **210,999,689.86** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 868,500.00 | 0 |
| 35420 | Аж ахуйн материал | 763,000.00 | 572,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 318,750.00 | 1,194,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 176,650,987.52 | 209,233,089.86 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,155,980,950.63** | **1,039,162,621.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,155,980,950.63** | **1,039,162,621.14** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **967,672,887.95** | **852,456,121.14** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 766,007,185.68 | 766,007,185.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -167,915,243.37 | -224,259,522.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 357,808,940.95 | 405,514,899.77 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -168,963,863.43 | -246,646,467.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 223,628,696.45 | 252,499,522.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -101,548,721.01 | -146,481,447.02 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 26,697,691.50 | 32,831,291.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -14,024,834.95 | -14,567,951.92 |
| 39217 | Ном | 45,983,036.13 | 27,558,610.90 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **188,308,062.68** | **186,706,500.00** |
| 39301 | Програм хангамж | 6,545,000.00 | 6,545,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,380,937.32 | -2,982,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 183,144,000.00 | 183,144,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,492,624,689.83** | **1,507,491,114.24** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,492,624,689.83** | **1,507,491,114.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,492,624,689.83** | **1,507,491,114.24** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 698,142,362.18 | 698,142,362.18 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 698,142,362.18 | 698,142,362.18 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-425,674,219.55** | **-410,307,164.54** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,918,298,909.38 | -425,173,588.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,492,624,689.83 | 14,866,424.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,220,156,547.20 | 1,219,655,916.60 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,492,624,689.83** | **1,507,491,114.24** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,168,581,843.53** | **2,066,810,787.31** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,392,668,842.51** | **106,044,894.38** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,392,668,842.51** | **106,044,894.38** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **23,031,100.00** | **47,344,148.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 150,648.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,031,100.00 | 47,193,500.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,199,716,957.97 | 30,812,105.32 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 169,920,784.54 | 27,888,641.06 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,775,913,001.02** | **1,960,765,892.93** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,594,013,200.00** | **1,825,368,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,594,013,200.00 | 1,825,368,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,655,300.00** | **0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 600,000.00 | 0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,055,300.00 | 0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **162,244,501.02** | **135,397,792.93** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 162,244,501.02 | 135,397,792.93 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,675,957,153.70** | **2,030,327,774.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,675,957,153.70** | **2,030,327,774.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,509,523,594.71** | **1,896,688,171.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,055,513,012.00** | **1,299,917,633.76** |
| 210101 | Үндсэн цалин | 740,548,906.49 | 877,194,850.00 |
| 210102 | Нэмэгдэл | 267,373,220.56 | 370,496,607.01 |
| 210104 | Урамшуулал | 47,590,884.95 | 52,226,176.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **132,299,883.31** | **161,757,825.32** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,159,179.78 | 112,200,498.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,722,031.82 | 13,196,932.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,436,505.45 | 10,407,946.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,989,225.06 | 2,343,612.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,992,941.20 | 23,608,835.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **94,771,163.02** | **116,265,792.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,927,411.02 | 18,020,682.73 |
| 210302 | Түлш, халаалт | 67,033,688.00 | 81,746,416.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,810,064.00 | 16,498,694.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,616,300.00** | **0** |
| 210401 | Бичиг хэрэг | 255,500.00 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 160,000.00 | 0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 97,200.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,103,600.00 | 0 |
| **2105** | **Нормативт зардал** | **16,287,698.00** | **0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 665,400.00 | 0 |
| 210502 | Хоол, хүнс | 15,552,298.00 | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 70,000.00 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **23,584,302.00** | **7,491,780.00** |
| 210604 | Урсгал засвар | 23,584,302.00 | 7,491,780.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,030,632.02** | **15,608,364.36** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,024,200.00 | 6,382,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,006,432.02 | 9,226,164.36 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **176,420,604.36** | **295,646,774.80** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,993,772.08 | 75,246,140.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,662,919.94 | 20,077,788.72 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 114,763,912.34 | 200,322,846.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **166,433,558.99** | **133,639,603.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **166,433,558.99** | **133,639,603.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 120,220,921.00 | 112,928,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 46,399,237.99 | 20,711,300.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,492,624,689.83** | **36,483,013.14** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0** | **21,616,588.73** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0 | 21,616,588.73 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,492,624,689.83** | **14,866,424.41** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,798,944,101.02** | **2,008,110,040.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,031,100.00** | **47,344,148.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **23,031,100.00** | **47,344,148.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **23,031,100.00** | **47,344,148.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 150,648.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,031,100.00 | 47,193,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,775,913,001.02** | **1,960,765,892.93** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,594,013,200.00** | **1,825,368,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,594,013,200.00 | 1,825,368,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,655,300.00** | **0** |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 600,000.00 | 0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,055,300.00 | 0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **162,244,501.02** | **135,397,792.93** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 162,244,501.02 | 135,397,792.93 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,569,990,094.34** | **1,834,514,739.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,569,990,094.34** | **1,834,514,739.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,403,369,935.35** | **1,699,733,486.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,055,513,012.20** | **1,299,917,633.76** |
| 210101 | Үндсэн цалин | 752,244,547.55 | 876,033,304.04 |
| 210102 | Нэмэгдэл | 258,715,027.70 | 367,699,609.14 |
| 210104 | Урамшуулал | 44,553,436.95 | 56,184,720.58 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **132,299,883.11** | **161,757,825.32** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 91,159,179.58 | 111,362,060.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,717,927.32 | 13,033,777.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,411,222.65 | 10,352,301.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,994,951.14 | 2,445,197.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,016,602.42 | 24,564,488.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **94,671,163.02** | **116,265,792.93** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,927,411.02 | 18,020,682.73 |
| 210302 | Түлш, халаалт | 66,933,688.00 | 81,746,416.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,810,064.00 | 16,498,694.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **697,450.00** | **0** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 697,450.00 | 0 |
| **2105** | **Нормативт зардал** | **14,896,298.00** | **2,867,940.00** |
| 210502 | Хоол, хүнс | 14,896,298.00 | 2,867,940.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,661,552.00** | **10,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 27,661,552.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,813,662.02** | **17,148,364.36** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,024,200.00 | 6,382,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,789,462.02 | 10,766,164.36 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **66,816,915.00** | **91,775,930.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,684,400.00 | 72,527,630.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,132,515.00 | 19,248,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **166,620,158.99** | **134,781,253.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **166,620,158.99** | **134,781,253.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 120,220,921.00 | 114,069,953.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 46,399,237.99 | 20,711,300.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **228,954,006.68** | **173,595,301.56** |

| | | | |
|---|---|---|---|
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **71,027,905.00** | **74,309,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **71,027,905.00** | **74,309,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **71,027,905.00** | **74,309,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 71,027,905.00 | 74,309,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-71,027,905.00** | **-74,309,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **157,926,101.68** | **99,286,301.56** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 157,926,101.68 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 157,926,101.68 | 257,212,403.24 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **698,142,362.18** | **1,220,156,547.20** | **-425,674,219.55** | **1,492,624,689.83** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 500,630.60 | 500,630.60 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **698,142,362.18** | **1,220,156,547.20** | **-425,173,588.95** | **1,493,125,320.43** |
| **4** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | -500,630.60 | | -500,630.60 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| **6** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| **7** | Өмчид гарсан өөрчилөлт | | | | |
| 8 | Зарласан ногдол ашиг | | | | |
| **9** | Тайлант үеийн үр дүн | | | 14,866,424.41 | 14,866,424.41 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **698,142,362.18** | **1,219,655,916.60** | **-410,307,164.54** | **1,507,491,114.24** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,165,414,192.93** | **1,908,823,739.37** | **256,590,453.56** | 88.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,165,414,192.93** | **1,908,823,739.37** | **256,590,453.56** | 88.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,007,807,692.93 | 1,774,042,486.37 | 233,765,206.56 | 88.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,499,918,500.00** | **1,299,917,633.76** | **200,000,866.24** | 86.7 |
| 210101 | Үндсэн цалин | 1,015,107,000.00 | 876,033,304.04 | 139,073,695.96 | 86.3 |
| 210102 | Нэмэгдэл | 420,427,600.00 | 367,699,609.14 | 52,727,990.86 | 87.5 |
| 210104 | Урамшуулал | 64,383,900.00 | 56,184,720.58 | 8,199,179.42 | 87.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **187,489,900.00** | **161,757,825.32** | **25,732,074.68** | 86.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,493,100.00 | 111,362,060.03 | 16,131,039.97 | 87.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,999,200.00 | 13,033,777.10 | 1,965,422.90 | 86.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,999,300.00 | 10,352,301.74 | 1,646,998.26 | 86.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,999,900.00 | 2,445,197.80 | 554,702.20 | 81.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,998,400.00 | 24,564,488.65 | 5,433,911.35 | 81.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **116,265,792.93** | **116,265,792.93** | **-** | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,020,682.73 | 18,020,682.73 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 81,746,416.20 | 81,746,416.20 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,498,694.00 | 16,498,694.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,950,000.00** | **2,867,940.00** | **82,060.00** | 97.2 |
| 210502 | Хоол, хүнс | 2,950,000.00 | 2,867,940.00 | 82,060.00 | 97.2 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,132,000.00** | **19,132,000.00** | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 19,132,000.00 | 19,132,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **19,114,700.00** | **17,148,364.36** | **1,966,335.64** | 89.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,382,200.00 | 6,382,200.00 | - | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,732,500.00 | 10,766,164.36 | 1,966,335.64 | 84.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **162,936,800.00** | **156,952,930.00** | **5,983,870.00** | 96.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,687,300.00 | 137,704,630.00 | 5,982,670.00 | 95.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,249,500.00 | 19,248,300.00 | 1,200.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **157,606,500.00** | **134,781,253.00** | **22,825,247.00** | 85.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **157,606,500.00** | **134,781,253.00** | **22,825,247.00** | 85.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 136,895,200.00 | 114,069,953.00 | 22,825,247.00 | 83.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,711,300.00 | 20,711,300.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,165,414,192.93** | **2,008,110,040.93** | **157,304,152.00** | 92.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,825,368,100.00** | **1,825,368,100.00** | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,825,368,100.00 | 1,825,368,100.00 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **135,397,792.93** | **135,397,792.93** | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 135,397,792.93 | 135,397,792.93 | - | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **204,648,300.00** | **47,344,148.00** | **157,304,152.00** | 23.1 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,382,200.00 | 150,648.00 | 6,231,552.00 | 2.4 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,340,000.00 | 47,193,500.00 | (6,853,500.00) | 117.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 157,926,100.00 | | 157,926,100.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 157,926,101.68 | (157,926,101.68) | 100.0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 257,212,403.24 | (257,212,403.24) | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | | - | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 69 | 69 | - | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 3 | (2.00) | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 53 | 52 | 1.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15 | 13 | 2.00 | |
| 620004 | Гэрээт ажилтан | - | 1 | (1.00) | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **640** | **1,041** | **-** | |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 640 | 1,041 | - | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 640 | 1,041 | - | |

## 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь "Аз жаргалтай, аливаад хариуцлагатай суралцагч" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06, 5 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон.*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*

  *1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*

  *2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл хангаж нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,866.2 мянган төгрөгөөр буюу 0.99 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 157,926.1 | 257,212.4 | 99,286.3 |
| Авлага | | | |
| Бараа материал | 178,717.1 | 211,116.1 | 32,398.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,155,980.9 | 1,039,162.6 | (116,818.3) |
| **Нийт хөрөнгө** | **1,492,624.7** | **1,507,491.1** | **14,866.2** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,492,624.7 | 1,507,491.1 | 14,866.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,492,624.7** | **1,507,491.1** | **14,866.2** |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 257,212.4 мянган төгрөг болж 99,286.3 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх "*Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй*" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 211,116.1 мянган төгрөг болж 32,398.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн БШУГ-аас 18,233.5 мянган төгрөгийн сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,553,0 мянган төгрөгийн эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэглэгдэхүүн, Синапс ХХК-аас 7,545.7 мянган төгрөгөөр технологийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй хүлээн авснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,039,162.6 мянган төгрөг болж 116,818.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 74,309.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн БШУГ-аас 2,987.2 мянган төгрөгийн ном сурах бичиг, Синапс ХХК-аас 6,178.7 мянган төгрөгөөр технологийн сургалтын хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 21,646.2 мянган төгрөгөөр тавилга үнэ төлбөргүйгээр хүлээн авч, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 сарын 13-ны өдрийн 85 дугаар тогтоолоор 40,835.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталснаас тус тус шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,834.878.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн боловч 1,501,589.9 мянган төгрөгийн төсөв анх батлагдан иржээ.

Төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар 2023 оны 1,2,3,4,5,6,9,10,11,12-р саруудад нийт 10 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,825,368.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135,397.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,382.2 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 40,340.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 157,926.1 мянган төгрөг нийт 2,165,414.2 мянган төгрөгөөр төсвийг эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 2,165,414.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,908,823.8 мянган төгрөгийг зарцуулж, 256,590.4 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,908,823.8 мянган төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 203,178.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа ны зардлыг 24,520.2 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 22,825.3 төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 5,093.0 | 5,093.0 | - | 100.0 |
| 2 | 80312-Сургалт семинар | 4,415.9 | 3,994.8 | 421.1 | 90.5 |
| 3 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 7,399.1 | 2,902.0 | 4,497.1 | 39.2 |
| 4 | 81801-үдийн цай хөтөлбөр | 136,895.2 | 114,069.9 | 22,825.3 | 83.3 |
| 5 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 57,829.9 | 57,058.8 | 771.1 | 98.7 |
| 6 | 81823-Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 13,991.0 | 13,970.4 | 20.6 | 99.9 |
| 7 | 81834-Боловсролын стандарт, сургалты | 1,533,557.7 | 1,330,378.8 | 203,178.9 | 86.8 |
| 8 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 223,112.4 | 198,592.1 | 24,520.3 | 89.0 |
| 9 | 81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 41,189.3 | 40,834.5 | 354.8 | 99.1 |
| 10 | 81844-Сурах бичгийн түрээс | 6,382.2 | 6,382.2 | - | 100.0 |
| 11 | 83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 150.7 | 149.5 | 1.2 | 99.2 |
| | **Дүн** | **2,030,016.4** | **1,773,426.0** | **256,590.4** | **87.4** |
| 12 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 135,397.8 | 135,397.8 | - | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Нийт** | **2,165,414.2** | **1,908,823.8** | **256,590.4** | **88.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *"Чиглэл хүргүүлэх тухай"* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул "Алтан тариа" ХХК, "Таван оргил хангай" ХХК, "Цахим ертөнц" ХХК-иуд болон иргэн М.Майнбаяр, Д.Мөнхцэцэг Ц.Цэсэм, Б.Сэлэнгэсайхан, Б.Шинэбаяр, Д.Баатар, Д.Зууннаст, Б.Од, Г.Амгаланбаатар, Ж.Оюундэлгэр, С.Энхтайван нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит" ХХК-ийн аудитор О.Чулуунбаатар, Ю.Уртнасан, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит" ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,675,957.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,759.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 166 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

- Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 136,895.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Алтан тариа” ХХК, “Таван оргил хангай” ХХК, “Цахим ертөнц” ХХК-иуд болон иргэн М.Майнбаяр, Д.Мөнхцэцэг Ц.Цэсэм, Б.Сэлэнгэсайхан, Б.Шинэбаяр, Д.Баатар, Д.Зууннаст, Б.Од, Г.Амгаланбаатар, Ж.Оюундэлгэр, С.Энхтайван нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй, мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 5,422.0 | 1 | 5,422.0 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 416.1 | 1 | 416.1 | 100.0 |
| **Нийт дүн** | **2** | **5,838.1** | **2** | **5,838.1** | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | | | | 1 | | | |
| **Дүн** | **1** | | | | **1** | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | | | | **1** | | | |